

Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга,
нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 10 дугаар хавсралт


**Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,
төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр: **Аймгийн Засаг дарга**

(Хуулийн 6.4.8, 6.8.1 заалтын хүрээнд)

Д/д	Шийдвэр гаргагч	Шийдвэрийн огноо	Шийдвэрийн дугаар	Төрөл/хөрөнгө зарцуулах, өр авлага үүсгэх	Шийдвэрийн хуулбар
1	Аймгийн Засаг дарга	2023.10.12	A/521	Дэмжлэг үзүүлэх тухай	
2	Аймгийн Засаг дарга	2023.10.30	A/542	Хөрөнгө зарцуулах тухай	
3	Аймгийн Засаг дарга	2023.11.06	A/562	Дэмжлэг үзүүлэх тухай	
4	Аймгийн Засаг дарга	2023.11.06	A/568	Хөрөнгө зарцуулах тухай	

Төрийн сангийн мэргэжилтэн: Б.Гантулга



Холбогдох утас: 70384096, 88089938
И-мэйл хаяг: b.gantulga@khs.gov.mn



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/521

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 21 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Хүндийн өргөлтийн Улсын болон аймгийн холбооноос ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх хүрээнд Хүндийн өргөлтийн улсын аварга шалгаруулах тэмцээний үйл ажиллагаанд 5,000,000 (Таван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх дэмжлэгийн 5,000,000 (Таван сая) төгрөгийг аймгийн Засаг дарга данснаас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Батбилгүүн)-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/542

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 13 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 21 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Гавьяат багш цолоор шагнагдсан Н.Баатар-Очирт хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний зардалд 2.000.000 (хоёр сая) төгрөг зарцуулсугай.
2. Дээрх зардлын 2.000.000 (хоёр сая) төгрөгийг аймгийн Засаг дарга дансны "Иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлтийг шийдвэрлэх зардал"-аас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-өсөх)-т зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 06 өдөр

Дугаар А/562

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүгд найрамдах Солонгос улсад Нэгдсэн Үндэсний Байгууллагын Гамшгийн эрсдэлийг бууруулах газрын Зүүн Хойд Азийн бүсийн төв, Дэлхийн боловсрол сургалтын төвөөс “Орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөлтөд уур амьсгалын өөрчлөлийг сааруулах үйл ажиллагааг тусгаж хэрэгжүүлэх нь” сэдэвт сургалтад Хөвсгөл аймгийг төлөөлөн Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, хошууч Л.Бямбасүрэн оролцох болсон тул 1.400.000 (Нэг сая дөрвөн зуун мянган) төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2. Дээрх дэмжлэгийн 1,400,000 (Нэг сая дөрвөн зуун мянган) төгрөгийг “Засаг даргын иргэн, байгууллагын өргөдөл, гомдол шийдвэрлэх сан”-аас шийдвэрлэхийг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ





МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 06 өдөр

Дугаар А/508

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газраас ирүүлсэн хүсэлтийн шийдвэрлэх хүрээнд Цагдаагийн газрын тээврийн хэрэгслийн завсар үйлчилгээнд шаардлагатай зардалд 3,500,000 (Гурван сая таван зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 3,500,000 (Гурван сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг дарга дансны "Иргэд, байгууллагаас ирүүлсэн санал хүсэлтийг шийдвэрлэх зардал"-аас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ